

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД, БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД,  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН  
ХАМТАРСАН ТУШААЛ

2020 оны 02 дугаар 28 өдөр

Дугаар А/145, А/57, А/37 Улаанбаатар хот

Эмнэлгийн тусламж, үйлчилгээг зохицуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 10 дугаар зарлиг, Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай 62 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 4 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь.

1. Коронавируст халдвар (Ковид-19)-тай өвчтөнд эмнэлгийн тусламж үзүүлэх 570 орыг дэлгэх, бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг Цэргийн төв эмнэлэг /хурандаа С.Батболд/-т үүрэг болгосугай.

2. Коронавируст халдвар (Ковид-19)-тай өвчтөнд эмнэлгийн тусламж үзүүлэх үед Цэргийн төв эмнэлгийн үзүүлж буй тусламж үйлчилгээг шилжүүлэх хуваарийг хавсралтаар баталсугай.

3. Тушаалын нэг, хоёрдугаар заалтыг хэрэгжүүлж эхлэх чиглэлийг авснаас хойш 24 цагийн дотор нүүлгэн шилжилт хийх, иргэдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлэх, халдвараас сэргийлэх хяналтыг чанд баримталж ажиллахыг Цэргийн төв эмнэлэг /хурандаа С.Батболд/, Төрийн тусгай алба хаагчдын нэгдсэн эмнэлэг /дэд хурандаа Л.Баттөр/, Улсын нэгдүгээр төв эмнэлэг /Т.Мөнхсайхан/, Улсын хоёрдугаар төв эмнэлэг /С.Энхболд/, Гэмтэл согог, судлалын үндэсний төв /Э.Галбадрах/, Нийслэлийн эрүүл мэндийн газар /Л.Төмөрбаатар/-т тус тус үүрэг болгосугай.

4. Коронавируст халдвар (Ковид-19)-тай өвчтөнд эмнэлгийн тусламж үзүүлэх бэлтгэлийг хангахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, халдварын сэргийлэлт хяналт, тандалт судалгаа хийж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Нямхүү/, Эрүүл мэндийн яамны дэргэдэх мэргэжлийн салбар зөвлөлийн ерөнхий мэргэжилтнүүдэд тус тус даалгасугай.

5. Цэргийн төв эмнэлгийн эмнэлгийн тусламж үйлчилгээний санхүүжилтийн асуудлыг холбогдох хуульд нийцүүлэн шуурхай шийдвэрлэж байхыг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Я.Амаржаргал, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга бригадын генерал Х.Батбилэг, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Г.Баясгалан нарт зөвшөөрсүгэй.

6. Эмнэлгийн тусламжийн бэлэн байдал, эрсдлийг бууруулах, хариу арга хэмжээ авахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газар /Б.Цогтбаатар/, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газар /Я.Буянжаргал/, Батлан хамгаалах яамны

Стратегийн бодлого, төлөвлөлтийн газар /бригадын генерал Г.Сайханбаяр/, Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Э.Энхтуяа/-т тус тус даалгасугай.

7. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн дэд сайд Л.Бямбасүрэн, Батлан хамгаалахын дэд сайд Т.Дуламдорж, Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Г.Элбэгсайхан нарт даалгасугай.







**ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛГИЙН ҮЗҮҮЛЖ БҮЙ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ ШИЛЖҮҮЛЭХ ХУВААРЬ**

№	Тусламж, үйлчилгээ	Эрүүл мэндийн байгууллага
1	Хугацаат болон гэрээт цэргийн албан хаагч, Үндэсний батлан хамгаалах их сургуулийн сонсогч нарт үзүүлдэг тусламж, үйлчилгээ	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг
2	Багахангай, Баянзүрх дүүргийн иргэдийн яаралтай мэс заслын тусламж үйлчилгээ	Улсын нэгдүгээр төв эмнэлэг
3	Насанд хүрэгчдийн хордлогын яаралтай тусламж үйлчилгээ	Улсын нэгдүгээр төв эмнэлэг
4	Халуун, хүйтэн зэвсгийн гэмтлийн яаралтай тусламж үйлчилгээ	Гэмтэл согог судлалын үндэсний төв
5	Батлан Хамгаалах Яам, Зэвсэгт Хүчний Жанжин Штабын харьяа анги, байгууллагын офицер, ахлагч болон чөлөөнд байгаа офицер, ахлагч, ахмад дайчид, энгийн албан хаагчдад үзүүлдэг тусламж үйлчилгээ	Иргэний оршин суугаа харьяа дүүргийн эмнэлэгт
6	Хүүхдийн тусламж, үйлчилгээ	Иргэний оршин суугаа харьяа дүүргийн эмнэлэгт